



Хил судлалын онол, практик

ХИЛИЙН ЦЭРГИЙН ТАКТИКИЙН ОНОЛ

Хилийн цэргийн тактик нь улсын хил хязгаар нутагт Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад чиглэгдсэн ХЦ-ийн салбар анги, нэгтгэлүүдийн алба үйл ажиллагааг бэлтгэх, явуулахтай холбогдсон онол практикийн цогц асуудал юм.

Энэ тактик нь улсын хил хамгаалах урлагийн нэгэн хэсэг бөгөөд зэвсэгт тэмцлийн тактик үйл ажиллагаатай салшгүй холбоотой.

Хилийн цэргийн тактикийн онол нь суман хороо, нэгтгэлүүдийн хил хамгаалалтанд хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэс бөгөөд улсын хил хамгаалалтын мөн чанар, агуулгыг судалж түүний зүй тогтол, зарчмуудыг нээн үзүүлэхээс гадна, хил хамгаалах явцад хуримтлагдсан тэргүүн туршлагыг баяжуулж шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг харгалзан үүний үндсэн дээр тухайн үе шатны тодорхой нөхцөлд дээд зэргээр тохирох үйл ажиллагааг бэлтгэх, явуулах хэлбэр, арга замуудыг тодорхойлж өгдөг.

Онолын үр дүн, судалгааны асуудлаар гаргасан ХЦ-ийн тактикийн дүгнэлтүүд нь хилийн асуудлаар байгуулсан Монгол улсын олон улсын гэрээ хэлэлцээр, хилийн тухай хууль тогтоомж, хил хамгаалалтын дүрэм, удирдлагын бичиг баримтууд, шинжлэх ухааны судалгааны ажил, сурах бичиг, сургалтын гарын авлага болон бусад хэвлэл мэдээллийн бичвэрүүдийн хэлбэрээр тодорхой зарчим, дүрэм, хэм хэмжээ, санал зөвлөмжийн хэлбэрээр тусгагдсан байдаг.

Хилийн цэргийн тактикийн онол нь хил хамгаалалтын ойрын ба хэтийн төлөв, нөхцөл байдлын өөрчлөлтийг урьдчилан мэдэрч шийдвэрлэвэл зохих шинэ асуудлуудыг дэвшүүлэн тавьдаг.

Онол нь практик дээр үндэслэгдэж, түүнийхээ арга замыг нээн өгдөг бол практик нь онолд тулгуурлаж суман, хороо, анги нэгтгэлүүдийн алба үйл ажиллагааны явцад тохиолдсон амьдралын үнэн бодит материалуудаар онолоо шинэчлэн баяжуулж хөгжилд нь түлхэц болдог.

“Онол нь практикаар амилж практикаар шалгагддаг” гэж сургасан байдаг. Хилийн цэргийн тактикийн онолын хөгжилт Хилийн

цэргийн оператив урлагт ч төдийгүй хил хамгаалах урлагийн хөгжилд онцгой нөлөө үзүүлдэг.

Хилийн цэргийн тактик нь Хилийн цэргийн оператив урлагийн ашиг сонирхолд захирагдаж түүний шаардлагуудыг удирдлага болгодог.

Улсын хил хамгаалалт нь нийгмийн бусад үзэгдлүүдтэй харилцан шүтэлцээтэй явагддаг тул Хилийн цэргийн тактик улсын хилийн эрх ашигт хамааралтай техник, хууль зүй, түүхийн зэрэг шинжлэх ухааны бусад салбаруудтай нягт холбоотой хөгждөг.

Орчин үед Хилийн цэргийн тактикийн үүрэг улам өсөж тактикийн онолыг хөгжүүлэх асуудал чухлаар тавигдаж байна. Энэ нь улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах, ХЦ-ийн үйл ажиллагааны тактикийн хэлбэр, аргыг хадгалан үргэлжлүүлэх, улам боловсронгуй болгох, удирдлагын системийн нийтлэг нэгжүүдийн тактикийн удирдлаганд ажиллаж байгаа дарга нарын албан үүрэг гүйцэтгэх мэдлэг чадвар дадлагыг эрс нэмэгдүүлэх шаардлагад үндэслэгдэж байна.

ХЦ-ийн тактик нь улсын хил хамгаалах урлагийн үндсэн салбар мөн бөгөөд ХЦ-ийн алба үйл ажиллагааны үндсэн хэсэг, сургалтын гол хичээл, суралцах зүйл юм.

ХЦ-ийн тактикийн хөгжлийн түвшин нь улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах гол хүчин зүйл болсон штаб, офицеруудын тактикийн бэлтгэл сургуульд чанарын онцгой нөлөө үзүүлдэг. Тэрээр өөрийн судлах зүйлүүдтэй. Хилийн манаа /экипаж/, харуул, салбар /суман, комендатур/, анги /хороо/, нэгтгэл /ХТУГ/-ийн нэгжийн алба үйл ажиллагааны хэлбэр зэрэг нь ХЦ-ийн тактикийн гол судлах зүйл бөгөөд тактик нь тасралтгүй хөгжиж байдаг.

Тактик нь улсын хил хамгаалах урлагийн хамгийн эрчимтэй салбарын хувьд хил хамгаалалтын нөхцөл, хэлбэр, аргын бага ч гэсэн өөрчлөлтийг өөртөө тусгаж түүнийхээ ачаар боловсронгуй болж шинэчлэгдэн сайжрах ёстой.

ХЦ-ийн тактикийн хөгжилтөнд олон янзын хүчин зүйлүүд нөлөөлдөг. Тэдгээрийг дотор нь **объектив ба субъектив, чухал ба чухал бус, урт хугацааны ба богино хугацааны гэж ангилж болох талтай.**

Объектив хүчин зүйлд: нийгэм, улс төр, эдийн засаг, хууль зүй, үзэл суртал, цэргийн шинж чанартай зүйлүүд хамаарна.

Эдгээр хүчин зүйлүүд нь улсын хил хамгаалах үйл ажиллагаанд тактикийн ямар хэлбэр аргыг сонгон авах шаардлагатайг харуулсан бодит нөхцөлүүдийг агуулж байдаг. Өнөөгийн нөхцөлд нийгэм улс төр, эдийн засгийн байдал ХЦ-ийн тактикт тодорхойлох нөлөө үзүүлж байна. Тухайлбал сүүлийн 10 жилд хялбар аргаар баяжих зорилгоор улсын хил зөрчих гэмт үйлдлүүд эрс өссөн, төрийн жолоо барих эрх улс төрийн нэг хүчнээс нөгөө хүчинд шилжих бүрд хилийн талаар гаргасан хууль

ХИЛ СУДЛАЛ

тогтоомжуудад өөрчлөлт орох, ХЦ-ийн харъяалал, бүтэц, удирдлага өөрчлөгдөх гэх мэт.

Хилийн зөрчлийн тооны өсөлт төдийгүй хил зөрчигчдийн зохион байгуулалт, арга улам нарийсч байгаа нь ХЦ-ийн тактикийг төгөлдөржүүлэхийг шаардаж байна. Цаг үе нийгмийн хөгжлийг дагаж хил зөрчигчид орчин үеийн өндөр хүчин чадалтай техник тээврийн хэрэгсэл, холбоо, зэвсэг, эдийн засгийн чадавхитай болсон төдийгүй хилийн зөрчлийн арга хэлбэрүүд ч өөрчлөгдөж байна.

Хилийн зөрчлийн ихэнх нь 2 талын иргэд улсын хилээр эд зүйлийг хууль бусаар нэвтрүүлэх, мал хулгайлах зорилготойгоор богино зайд явагдаж хууль бус ажиллагаандаа хилчид, хууль хяналтын байгууллагын ажилтнууд, олонд нэр нөлөөтэй хүмүүсийг татан оролцуулахыг эрмэлзэх болжээ. Энэ нь хил хамгаалалтын хэлбэр аргыг тактикийн нэгж бүрт оновчтойгоор хэрэгжүүлэх боловсронгуй болгох, ХЗГБЧ болон хил зөрчигч нуугдаж /явж/ болзошгүй газар орныг эргэн харах, тэдгээрт хүч хэрэгслэлийг оновчтой төвлөрүүлэх зэрэг ажиллагааг шинэ шатанд гаргахыг зүй ёсоор шаардаж байна.

ХЦ-ийн тактикийн хөгжлийн шийдвэрлэх хүчин зүйл түлхэц нь орчин үеийн шинжлэх ухаан техникийн дэвшил юм. Цэргийн онолын тэргүүний сэтгэлгээнд тулгуурлаж үүссэн шинжлэх ухаан техникийн дэвшил нь бүхийл үйл ажиллагаанд гүн нэвтэрч ХЦ-ийн өмнө шинэ шинэ асуудлуудыг дэвшүүлэн тавьж байна.

Нэгдүгээрт. ХЦ-ийн суман хороо нэгтгэлүүдийн техникийн хангамжийн өсөлтийн үр дүнг харгалзсан тоон болон чанарын дүн шинжилгээний үндсэн дээр улсын хил хамгаалалтын илүү үр ашигтай хэлбэр, аргыг тогтоож хэрэгжүүлэх;

Хоёрдугаарт. Хүн техник хоёрын оновчтой харьцааг үндэслэлтэй зөв тогтоох;

Гуравдугаарт. Хил хамгаалах урлаг, оперативийн урлаг, тактикийг улам боловсронгуй болгон хөгжүүлэх;

Улсын хил хамгаалалтын техник хэрэгслийг орчин үеийн түвшинд хүргэх нь ХЦ-ийн тактикийн хөгжилтийг төдийгүй, хилийн суман хороо, нэгтгэлүүдийн бүтэц, зохион байгуулалт, хил хамгаалалтын шинж төлөв, хэлбэр, аргыг ч үндсээр нь өөрчлөх хүчин зүйл болох юм.

“Тактик нь цэргийн техникийн хөгжлийн түвшингээс шууд хамаардаг” гэж Ф.Энгельс тэмдэглэж байв.

ХЦ-ийн тактикт онцгой нөлөөлдөг нэг хүчин зүйл нь физик газар зүйн нөхцөл юм. Байгаль цаг уур, физик газар зүйн ямар ч хүнд нөхцөлд улсын хилийг найдвартай хамгаалах боломжийг орчин үеийн байлдааны болон тусгай техник хэрэгсэл дүүрэн хангаж байна. Тэдгээр нь практик үр дүнтэй тогтмол хэрэглэгдэж байгаагаас гадна хэрэгцээ нь өдрөөс өдөрт улам өссөөр байна. Гэхдээ техник хэрэгслийн үр ашиг нь янз бүрийн

нөхцөлд харилцан адилгүй тул физик газар зүйн онцлогийг сайтар тооцох нь зөв юм.

Иймд хил хамгаалалтын шинэ техник хэрэгслэлийг сонгон нэвтрүүлэх, зохион бүтээхдээ ХЦ-ийн үйл ажиллагааны онцлогийг харгалзаад зогсохгүй физик газар зүйн нөхцөл байдлыг ч тооцох нь зүйтэй.

Субъектив хүчин зүйлд: суман хороо, нэгтгэлүүдийн бие бүрэлдэхүүн, дарга захирагч нарын үйл ажиллагаатай холбоотой хүчин зүйлүүд хамаарна.

Объектив хүчин зүйлүүд нь ХЦ-ийн тактикийн зүй тогтлыг агуулдаг бол субъектив хүчин зүйлүүд нь үүссэн тухайн нөхцөл байдалд сонгон хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр аргын бодит зүй тогтол, хүмүүсийн ухамсартай үйлдлийг нээн харуулдаг. Өөрөөр хэлбэл субъектив хүчин зүйлүүд нь ХЦ-т байгаа бүх боломжийг бодит зүйл болгон хувиргадаг.

Улсын хил хамгаалалтын хувь заяанд хүний хүчин зүйл голлох үүрэг гүйцэтгэдэг. Шинжлэх ухаан техникийн дэвшлээс гадна орчин үед хүний хүчин зүйл хамгийн чухлаар тавигдаж ХЦ-ийн бие бүрэлдэхүүнээс цэвэр ариун ёс суртахуун, эх оронч дайчин чанар, ерөнхий боловсролын болон мэргэжлийн бэлтгэлийн өндөр түвшинг цаг үе шаардаж байна. Улсын хил хамгаалалтын орчин үеийн нөхцөл байдал офицерын бүрэлдэхүүний үүрэг ач холбогдлыг ихээхэн нэмэгдүүлж байна. Офицер боловсон хүчнүүд улсын хил хамгаалалтыг шууд гардан зохион байгуулж удирдан, бие бүрэлдэхүүнийг сургаж хүмүүжүүлэн, бүх талын хангалтыг хийдэг тул энэ ч зүй ёсны асуудал юм. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхийн тулд офицеруудад мэргэжлийн өргөн мэдлэгээс гадна бүтээлч идэвхи, сэтгэлийн хат, цагийн байдлын өөрчлөлтийг цаг тухайд нь мэдэрч үнэлэх, хил зөрчигчдөд гэнэт хэрэглэгдэх үйл ажиллагааны хэлбэр аргыг зөв сонгож хэрэгжүүлэх чадвар туйлын чухал юм.

“Олон янзын арга хэрэгслэлүүдээс тухайн тохиолдолд аль илүү тохиромжтойг нь сонгож чаддаг байх нь цэргийн даргын урлаг байх ёстой. Цэргийн онол нь тэдэнд ямар ч загвар болсон бэлэн шийдвэр гаргаж өгдөггүй, зөвхөн удирдан чиглүүлэх эхлэл болдог” гэж М.В.Фрунзе сургажээ. Үйл ажиллагаандаа оновчтой арга зүйг тулгуураа болгосон хил хамгаалалтын мөн чанар, зүй тогтол, бодит хуулиудыг судлан танин мэдсэн, тэдгээрийг ашиглаж чаддаг офицер л улсын хил хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд шийдвэрлэх нөхцөл болно.

Тактик нь судлах зүйлээ байнга хадгалахын зэрэгцээ дотоод агууллагаа байнга төгөлдөржүүлж байдаг. ХЦ-ийн тактик нь бусад салбарын нэгэн адил бодит үзэгдлүүдийг тусгаж байдгийн хувьд жигд бус ч гэсэн тасралтгүй урагшлан хөгжсөөр ирсэн.

ХИЛ СУДЛАЛ

ХЦ-ийн. тактик нь улсын хил хамгаалах урлагийн салшгүй хэсгийн хувьд хил хамгаалалтын мөн чанарт гүн нэвтэрч түүний зүй тогтол, онцлогийг судалж түүхэн туршлага хуримтлуулсны үндсэн дээр дараах үүргийг хэрэгжүүлж байна.

-Улсын хил хамгаалахад хүч хэрэгслийг ашиглах зарчим, хэлбэр, аргыг боловсруулж, салбар анги нэгтгэлүүдийн боломжийг судалж, тэдгээрийн байр суурь, үүргийг тодорхойлох;

-Улсын хил хамгаалалтанд бусад байгууллагуудын хүч хэрэгслийг татан оролцуулах бололцоог судлан, харилцан ажиллагааны журмыг тогтоох;

-ХЦ-ийн тактикийн бүх нэгжийн удирдлага, штаб, дарга нарын үйл ажиллагааны зарчим арга барилыг дээшлүүлэх арга замыг тогтоох;

-Салбар анги нэгтгэлүүдийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны чиглэл, хэлбэр, арга, бэлтгэл сургуульд нөлөөлөх;

-Эсрэг талын хүч хэрэгсэл, үйл ажиллагааны арга хэлбэрийг судлах;

-Бүх төрлийн хангалтын асуудлуудыг судлах;

ХЦ-ийн тактик нь ерөнхий ба тухайн мэргэжлийн гэж хуваагдана.

ХЦ-ийн ерөнхий тактик нь улсын хилийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагааг бүх төрлийн хүч хэрэгслэлтэй хамтран бэлтгэх, явуулахтай холбогдсон онол практикийн цогц юм.

ХЦ-ийн ерөнхий тактикийн онол нь хилийн суман, хороо, нэгтгэлүүдийн хилийн алба, ШНА, хилийн төлөөлөгчийн ажиллагаа, тусгай болон байлдааны үйл ажиллагааны зүй тогтол, шинж төлөв, агуулгыг судалж, төрөл бүрийн хүч хэрэгслийн хамтарсан ажиллагааг бэлтгэн явуулах аргыг боловсруулж, тактикийн нэгжүүдийн байр суурь, үүрэг, боломж, үйл ажиллагааны хэлбэр, арга, харилцан ажиллагааны журмыг тодорхойлж өгдөг.

ХЦ-ийн ерөнхий тактикийн практикт улсын хилийг хамгаалахад бэлтгэх, хамгаалалтыг зохион байгуулах, явуулахтай холбогдсон ХЦ-ийн тактикийн нэгжүүдийн удирдлага, штаб, дарга нарын үйл ажиллагааг хамруулж үздэг.

ХЦ-ийн ерөнхий тактикийн үндэс нь хилийн манаа, харуул, суман, комендатур, хорооны үйл ажиллагааны тактик юм.

Улсын хил хамгаалалт нь ердийн, хүчжүүлсэн, тусгай, байлдааны хэлбэртэй байж болно.

Хил хамгаалалтын хэлбэрийн сонголт нь улсын хилийн ерөнхий нөхцлөөс хамаарна.

Улсын хилийн ерөнхий нөхцлийг дотор нь тайван цагийн ба цэрэг улс төрийн байдал хурцадсан үсийн нөхцөл гэж хоёр хувааж болно.

Тайван цагийн нөхцөлд улсын хил хамгаалалт нь ердийн ба хүчжүүлсэн хэлбэрээр явагдана.

Цэрэг улс төрийн байдал хурцадсан үеийн нөхцөлд хил хамгаалалт нь тусгай ба байлдааны хэлбэрээр явагдана.

Улсын хил зөрчсөн, зөрчихөөр бэлтгэж байгаа шинж тэмдэг илрээгүй, энэ тухай бодит мэдээлэл авагдаагүй тайван цагийн нөхцөлд улсын хил хамгаалалт **ердийн хэлбэрээр** явагдана.

Хилийн цагийн байдал өрнөж, улсын хил зөрчсөн, эсвэл хил зөрчихөөр бэлтгэж байгаа шинж тэмдэг илэрсэн, мэдээлэл авагдсан, хил хамгаалалтын ердийн хэлбэр нь хилийн хамгаалалтын найдвартай байдлыг хангаж чадахааргүй тайван цагийн нөхцөлд сумангийн дарга болон түүний дээд шатны ахлах даргын шийдвэрээр улсын хил хамгаалалтыг хүчжүүлсэн **хэлбэрээр** явуулна.

Улсын хил дээр нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, зэвсэггүй бөөн иргэд (дүрвэгсэд) улсын хил зөрчсөн, эсрэг талаас зэвсэггүй, өдөөн хатгалга үйлдэгдэж байгаа, онц байдал тогтоогдсон, цэрэг, улс төрийн байдал хурцадсан нөхцөлд улсын хил хамгаалалтыг **тусгай хэлбэрээр** явуулна.

Зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх тагнуулын ажиллагааг таслан зогсоох, зэвсэгт өдөөн хатгалгыг няцаах шаардлага гарсан үед цэрэг, улс төрийн байдал зэвсэгт тэмцэл хурцадсан үеийн нөхцөлд улсын хил хамгаалалтыг **байлдааны хэлбэрээр** хамгаална.

Хилийн цэргийн салбар, анги, нэгтгэлүүдийн үйл ажиллагааны тактикийн үндсэн хэлбэр нь хилийн алба, ШНА, хилийн эрэл, төлөөлөгчдийн ажиллагаа, тусгай ажиллагаа, байлдаан юм.

Хилийн цэргийн суман болон нэгтгэл орон тооны хүч хэрэгслээр улсын хилийг манах, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулахаар цэргийн болон инженер техникийн арга хэмжээг орон нутгийн иргэд, ХХТХ-ний гишүүд орон нутаг болон хууль хяналтын болон бусад байгууллагын оролцоотойгоор явуулахыг **хилийн алба** гэнэ.

Хилийн цэргийн салбар, анги, нэгтгэл нь улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийг Монгол Улсын олон улсын гэрээ, хилийн тухай хууль, тогтоосон журмын дагуу хилийн боомтоор шалган нэвтрүүлэх, хил зөрчигч, зөрчихийг завдагсадыг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэлд үзлэг хийх, хилийн боомтод мөрдөх журмыг сахиулахаар орон тооны хүч хэрэгслээр хил хяналтын байгууллагатай нягт харилцан ажиллагаатайгаар явуулж буй цэргийн арга хэмжээг **шалган нэвтрүүлэх алба** гэнэ.

Хилийн цэргийн салбар анги, нэгтгэлээс улсын хил зөрчигч, зөрчихийг завдагсад, хилийн районд нуугдсан хил зөрчигч, эрэн сурвалжлагдаж байгаа аюултай гэмт хэрэгтнийг илрүүлэн саатуулах зорилгоор хилийн бүс зурвас, боомтод шаардлагатай үед хил орчмын

ХИЛ СУДЛАЛ

нутаг дэвсгэрт орон тооны хүч хэрэгслэлээр ХХТХ-ний гишүүд, иргэд байгууллагын идэвхитэй оролцоотойгоор явуулж буй цэргийн болон дэглэмийн арга хэмжээг **хилийн эрэл** гэнэ.

Улсын хилийн асуудлаар байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тогтоосон дэглэмийг сахиулах, улсын хил дээр зөрчил будлиан гарахаас сэргийлэх, хил дээр үүссэн хилийн аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэх зорилгоор тусгайлан томилогдсон офицеруудын хүчээр хил залгаа улсын хил хамгаалах байгууллагатай хамтран явуулж буй дипломат арга хэмжээг **хилийн төлөөлөгчийн ажиллагаа** гэнэ.

Цэрэг, улс төрийн байдал хурцадсан үеийн нөхцөлд улсын хил дээр үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг журамлах, Монгол Улсын нутаг дэвсгэрт нэвтэрсэн зэвсэггүй бөөн иргэд (дүрвэгсэд)-ийг буцаан гаргах, өдөөн хатгалгыг таслан зогсоох, онц байдлын үеийн журмыг сахиулах зорилгоор хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт хууль хяналтын байгууллага, ХХТХ-ний идэвхтэй оролцоотойгоор Хилийн цэргийн хороо, суман, нэгтгэлээс явуулах цэргийн ажиллагааг **тусгай ажиллагаа** гэнэ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт өдөөн хатгалга, хорлон сүйтгэх тагнуулын ажиллагааг таслан зогсоох, зэвсэгт халдлагыг няцаах (бут цохих) буюу бусад үүргүүдийг биелүүлэх зорилгоор зэвсэгт хүчний хүч хавсаргасан ба дэмжих анги, салбаруудтай хамтран Хилийн цэргийн суман, хороо, нэгтгэлийн цохилт, гал маневрыг зорилго, байр, цагаар нь зохицуулан явуулах үйл ажиллагааг **байлдаан** гэнэ.

Хилийн цэргийн тактик нь Хилийн цэргийн үйл ажиллагааны аргыг улам төгөлдөржүүлдэг.

**Увс дахь хилийн хорооны захирагч
хурандаа Ч.Сайнтөр**